



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2012 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Дархан цаазат Богдхан уулын Төрхурх-Цэцээгүн чиглэлд явган аялалын замын амралтын цэгийг тохижуулах ажил зохион байгуулах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2009 оны 4/22 дугаар тогтоол, 2005 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотын аялал жуулчлал-2015 хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Монгол Улсын аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, "Улаанбаатар хотын аялал жуулчлал 2012" хөтөлбөрийн ажлын хүрээнд Богдхан уулын Төрхурх-Цэцээгүн чиглэлийн явган аялалын замыг тэмдэгжүүлэх, амралтын цэг, мэдээллийн самбар хийж тохижуулан иргэдийн явган аялал хийх таатай нөхцөлийг бүрдүүлэх, иргэдэд байгаль хамгаалах ажлыг сурталчилах, Дархан цаазат Богдхан уулын талаар мэдээлэл өгөх зорилгоор энэхүү ажлыг зохион байгуулахыг аттракци хариуцсан мэргэжилтэн /Д.Жаргалсайхан/-д, олон нийтэд хэвлэл мэдээллээр сурталчилан ажиллахыг вэб хуудас, дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн /Э.Билэгт/-д тус тус үүрэг болгосугай.

Хоёр. Богдхан уулын Төрхурх-Цэцээгүн чиглэлийн явган аялалын замыг тэмдэгжүүлэх, амралтын цэг, мэдээллийн самбар хийж тохижуулах ажлын удирдамжийг нэгдүгээр, үйл ажиллагааны төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Уг арга хэмжээний зардал 3.000.000 /гурван сая/ төгрөгийг тус газрын 2012 онд батлагдсан төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөс гаргахыг нягтлан /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Дээрх арга хэмжээг хөтөлбөрийн дагуу цаг хугацаанд нь амжилттай зохион байгуулж, хяналт тавих, шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг хотын аялал жуулчлал хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/-д даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР

115050000050



Нийслэлийн аялал жуулчлалын газрын даргын
2012 оны 09 сарын 13 өдрийн 13 тоот тушаалын
4-р хавсралт

Дархан цаазат Богдхан уулын Төрхурх – Цэцээгүн чиглэлийн
явган аялалын замыг тэмдэгжүүлэх, амралтын цэг тохижуулах,
мэдээлэлийн самбар хийж байрлуулах ажлын удирдамж

1. Зорилго:

Монгол Улсын аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх,
“Улаанбаатар хотын аялал жуулчлал 2012” хөтөлбөрийн ажлын хүрээнд Нийслэлийн
Аялал жуулчлалын газар, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын
захиргаатай хамтран Төрхурх-Цэцээгүн чиглэлийн явган аялалын замыг
тэмдэгжүүлэх, амралтын цэг, мэдээллийн самбар хийж тохижуулан иргэдийн явган
аялал хийх таатай нөхцөлийг бүрдүүлэх, иргэдэд байгаль хамгаалах ажлыг
сурталчилах, Дархан цаазат Богдхан уулын талаар мэдээлэл өгөх зорилгоор энэхүү
ажлыг хийж гүйцэтгэнэ.

2. Агуулга:

Дархан цаазат Богдхан уулын Төрхурх – Цэцээгүн чиглэлийн явган аялалын
замыг тэмдэгжүүлэх, амралтын цэг тохижуулан, мэдээлэлийн самбар хийж
гүйцэтгэснээр Богдхан ууланд явган аялал хийх гадаад дотоодын жуулчдад
зориулалтын баталгаажсан жимээр зүг чигээ алдалгүй аялах нөхцөлийг бүрдүүлэх,
үнэн зөв мэдээлэл өгөх, амрах бололцоо бүхий амралтын цэг байгуулахад оршино.

3. Хийж гүйцэтгэх ажил:

Төрхурх-Цэцээгүн аялалын маршрут тэмдэгжүүлэх, түр буудаллах амралтын
цэгийг тохижуулах, шинээр бий болгох, мэдээллийн санамж бүхий самбар
байрлуулах. Богдхан уулын оргил Цэцээгүн рүү Төрхурхаас гарах чиглэлийн явган
аялалын замын дагуу хийх ажил. Үүнд:

- Аялалаар явж буй иргэдийн түр буудаллаж амрах 1 цэгт ширээ, сандал,
мэдээллийн самбарыг сэргээн засварлах, хогийн цэг шинээр байгуулах
- Сүүдрэвчтэй амрах 1 цэгт хашлага, сандал, мэдээллийн самбар, хогийн
цэгийг сэргээн засварлах, хогийн цэг шинээр байгуулах
- Аялалаар явж буй иргэдийн түр буудаллаж амрах 1 цэгт ширээ, сандал,
мэдээллийн самбар, хогийн цэгийг шинээр хийх
- Цэцээгүн оргилд хогийн цэг байрлуулах

51/56

Дээрх ажилд Нийслэлийн Аялал жуулчлалын газраас 4 мэргэжилтэн, гэрээт 6 оюутан, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанаас 2 мэргэжилтэн, 3 байгаль хамгаалагч нийт 12 хүн 5 хоног ажиллана. Цэцээгүн оргил руу машин явах боломжгүй тул явганаар болон мориор ажлыг хийж гүйцэтгэнэ.

4. Хамрах хүрээ:

- Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа
- Нийслэлийн аялал жуулчлалын газар

Дээрх ажилд Нийслэлийн Аялал жуулчлалын газраас 4 мэргэжилтэн, гэрээт 6 оюутан, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанаас 2 мэргэжилтэн, 3 байгаль хамгаалагч нийт 12 хүн 5 хоног ажиллана. Цэцээгүн оргил руу машин явах боломжгүй тул явганаар болон мориор ажлыг хийж гүйцэтгэнэ.

5. Хугацаа:

- 2012 оны 09-р сарын 20-25-ны хооронд

6. Гарах үр дүн:


- Маршрутын дагуу түр амрах цэг аялагчидад зориулсан шрээ, сандал, мэдээллийн самбар, хогийн савтай болно. Аялагчид тув тухтай аялах нөхцөл бүрдэнэ, орчин тойрон цэвэр байх болно.
- Аялагчид Богд ууланд төөрөхгүй аялах боломжтой болно.
- "Улаанбаатар хотын аялал жуулчлал-2015" хөтөлбөрийн зорилт хэрэгжинэ

Удирдамж боловсруулсан:



Г.Баясгалан

/Ахлах мэргэжилтэн/



Д.Жаргалсайхан

/Арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн /



Нийслэлийн аялал жуулчлалын газрын даргын
20.08.09 оны 43 тоот тушаалын
-р хавсралт

Богд хан уулын Төрхүрх - Цэцээгүн оргил чиглэлийн явган аялалын
замыг тэмдэгжүүлэх, амралтын цэг, самбар, хогийн цэг байгуулах
ажлын төсвийн задаргаа

№	Нэр, төрөл	Хэмжээ	Материал	Тоо, ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Самбар	2,0*2,5	төмөр	1	450 000,0₮	450 000,0₮
2	Самбар	1,5*2,0	төмөр	1	400 000,0₮	400 000,0₮
3	Сүүдрэвч, шоно, багана		шоно	16	28 000,0₮	448 000,0₮
			багана	12	28 000,0₮	336 000,0₮
4	Дээврийн төмөр лист		төмөр	8	40 000,0₮	320 000,0₮
5	Хадаас	100- 150мм		15	2 000,0₮	30 000,0₮
6	Хар банз	5-н		10	13 000,0₮	130 000,0₮
7	Цемент	кг		50	800,0₮	40 000,0₮
8	Төмрийн будаг хар, шар	л		30	5 000,0₮	150 000,0₮
9	Замын хар	кг		10	400,0₮	4 000,0₮
10	Төмөр утас	ш		15	2 000,0₮	30 000,0₮
11	Шруп	9 мм		5	7 600,0₮	38 000,0₮
12	Самбрын хуулга	1,5*2,0	фосфорон	9	20 000,0₮	180 000,0₮
13	Шатахуун		АИ93	30	1 650,0₮	49 500,0₮
14	Ажиллах хүн 12хүн х 5 өдөр			50	7 500,0₮	375 000,0₮
15	Бусад					19500,0₮
	НИЙТ					3.000.000,0₮

Төсөв боловсруулсан: *Д. Жаргалсайхан* Д.Жаргалсайхан

/Арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн/

Төсөвийг хянасан:

П.Ариунаа

/Ня-бо/